



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/202

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД 81-16-20, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны IV/26 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.19 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Б” блокийн хэсэгчилсэн их засварыг, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээг 16,000,000 (арван зургаан сая) төгрөгөөр “Аслаан” ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гэрээнд заагдсан зөвлөх үйлчилгээний ажлыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Аслаан” ХХК (Ж.Банзрай)-д үүрэг болгосугай.

3.Дээрх зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4.Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Б” блокийн хэсэгчилсэн их засварын зураг төсөл боловсруулах ажлын санхүүжилтийг батлагдсан хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

632501029

Аймгийн Засаг даргын 2025 оны
03. дугаар сарын 31-ны/ний өдрийн А/202 дүгээр
захирамжийн хавсралт

**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРТ
ХАМРАГДСАН ОЮУТНУУДЫН НЭРС**

д/д	Овог	Нэр	Сургууль	Мэргэжил	Сургалтын төлбөр /төгрөг/
1	2	3	4	5	6
1	Энхбаатар	Удвал	МУИС	Аялал жуулчлал	1,000,000
2	Энхбаатар	Удвал	МУИС	Аялал жуулчлал	1,391,400
3	Ганболд	Идэржаргал	МУИС	Монгол хэл, уран зохиолын багш	4,795,700
4	Батсайхан	Анун	МУБИС	Түүх, нийгмийн ухааны багш	3,717,000
5	Цолмонбаяр	Насанжаргал	СУИС	Үндэсний хөгжим	1,889,500
6	Нэргүй	Наранбаатар	СУИС	Радио, телевиз, медиа урлаг	4,312,500
7	Дэлгэрсүрэн	Ганцогт	СУИС	Соёлын менежер	2,856,000
Нийт дүн					19,962,100